

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18-19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/168
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИТХ-ЫН АЖЛЫН
АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Р.МАШБАТ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй зүйл илэрлээ. **Үүнд:**

- Хууль, журмаар хүлээн зөвшөөрөгдөөгүй зардал гарган Хөвсгөл аймгийн Ардчилсан намд 44,000.0 мянган төгрөг, Монгол ардын намд 36,000.0 мянган төгрөг, бие даан нэр дэвшигч Д.Лхагвасүрэнд 2,000.0 мянган төгрөг нийт 82,000.0 мянган төгрөгийн дэмжлэгийг тус тус олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2."өрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3."хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардлыг 41 төлөөлөгчийн хувийн дансаар дамжуулан нийт 205,000.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.1.4. хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.8."Төлөөлөгчийн зардлыг бэлнээр олгохгүй бөгөөд үнийн нэхэмжлэх болон бусад баримтыг үндэслэн зардлын хязгаарт багтаан холбогдох санхүүжилтийг тухайн байгууллагад шилжүүлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлийг материаллаг хэмжээний зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг түвшнээс 280,611.5 мянган төгрөгөөр давсан.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Монгол Улсын үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойн арга хэмжээг Улсын Их Хурлын 2021 оны 97 дугаар тогтоолын дагуу орон нутагт зохион байгуулж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын төсвөөс 775.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч үр ашиггүй зардал гаргасан, бүсийн сургалтын арга хэмжээний зардалд 3,182.8 мянган төгрөгийг хоол хүнс, бэлэг дурсгалын зүйл, ус ундааны зардалд зуруулсан, санхүүгийн тайлангийн тодруулга тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн ирүүлээгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын ажлын албаны дарга нь аймгийн ИТХ-ын даргаар 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулан хэрэгжилтийг 88.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгсгөлөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,742,322.63	13,684,372.00
33	АВЛАГА	79,800.63	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	79,800.63	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	11,662,522.00	13,684,372.00
354	Хангамжийн материал	11,662,522.00	13,684,372.00
35410	Бичиг хэргийн материал	1,820,256.00	1,959,256.00
35420	Аж ахуйн материал	1,482,780.00	1,905,630.00
35430	Сэлбэг хэрэгсэл	562,200.00	692,200.00
35450	Барилгын засварын материал	241,000.00	241,000.00
35470	Бусад хангамжийн материал	7,556,286.00	8,886,286.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	159,544,369.78	122,444,773.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	159,544,369.78	122,444,773.79
392	Биет хөрөнгө	156,157,452.78	120,127,412.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,587,620.00	3,587,620.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-896,905.09	-1,195,873.45
39203	Авто-тээврийн хэрэгсэл	64,522,223.00	63,355,556.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-19,285,185.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,449,450.00	61,335,550.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,118,021.49	-18,640,252.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,169,647.23	37,430,647.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,101,977.44	-24,160,648.95
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,950,000.00	18,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,404,583.43	-300,000.00
393	Биет бус хөрөнгө	3,386,917.00	2,317,361.24
39301	Програм хангамж	3,743,167.00	2,941,667.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-356,250.00	-624,305.76
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	171,286,692.41	136,129,145.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	80,968.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	80,968.00
413	Өглөг	00.00	80,968.00
4136	Бусад өглөг	00.00	80,968.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	80,968.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	171,286,692.41	136,048,177.79
51	Засгийн газрын хувь оролцоо	171,286,692.41	136,048,177.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	134,621,105.00	134,621,105.00
51101	Өмч: - төрийн	134,621,105.00	134,621,105.00
512	Хуримтлагдсан үр дүн	36,467,169.91	1,427,072.79
51210	Өмнөх үеийн үр дүн	36,467,169.91	36,665,587.41
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-35,238,514.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	198,417.50	00.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	171,286,692.41	136,129,145.79

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	676,384,336.00	1,276,112,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,307,936.00	6,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	79,307,936.00	6,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,307,936.00	6,500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	79,307,936.00	6,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597,076,400.00	1,269,612,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	102,740,000.00	392,597,000.00

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	494336400.00	877015600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	494,336,400.00	877,015,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	567,869,493.09	1,262,416,251.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	567,869,493.09	1,262,416,251.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,607,994.84	872,791,559.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142,641,064.00	155,070,943.99
210101	Үндсэн цалин	92,548,738.00	113,350,627.99
210102	Нэмэгдэл	32,811,937.00	21,266,452.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,720,000.00	10,365,000.00
210104	Урамшуулал	6,560,389.00	10,088,864.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,978,253.37	19,628,260.61
210201	Тэтгэврийн даатгал	13,071,068.45	13,398,619.18
210202	Тэтгэмжийн даатгал	1,474,015.48	1,576,316.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,152,328.79	1,240,886.74
210204	Ажилгүйдлийн даатгал	288,082.69	310,221.70
210205	Эрүүл мэндийн даатгал	2,992,757.96	3,102,216.88
2104	Хангамж, бараа материалын зардал	18,721,544.36	22,254,834.32
210401	Бичиг хэрэг	1,342,800.00	980,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,600,209.61	17,103,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,478,034.75	3,609,384.32
210404	Ном, хэвлэл	95,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,205,500.00	466,150.00
2105	Нормативт зардал	616,700.00	215,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	616,700.00	215,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,099,900.00	10,407,000.00
210604	Урсгал засвар	8,099,900.00	10,407,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,644,000.00	6,194,500.00
210702	Дотоод албан томилолт	6,644,000.00	6,194,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,284,817.40	568,350,788.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,662,217.40	567,634,320.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,600.00	138,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.00	134,468.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	406,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,621,715.71	90,670,232.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,999,800.00	7,418,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,112,400.00	28,048,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,509,515.71	55,203,432.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	177,261,498.25	389,624,691.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,540,800.00	382,263,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,378,200.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	10,205,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,062,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	92,100,000.00	372,057,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,720,698.25	7,361,491.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,720,698.25	7,361,491.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	108,514,842.91	13,696,348.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	48,934,863.27
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	47,614,863.27
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,320,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-48,934,863.27
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	108,514,842.91	-35,238,514.62

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Лөгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	597,076,400.00	1,269,612,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597,076,400.00	1,269,612,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	102,740,000.00	392,597,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,340,000.00	12,597,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,400,000.00	360,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	494,336,400.00	877,015,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	494,336,400.00	877,015,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	555,161,800.00	1,210,393,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	555,161,800.00	1,210,393,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	378,161,801.75	820,769,208.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	142,641,064.00	155,070,943.99
210101	Үндсэн цалин	92,548,738.00	113,350,627.99
210102	Нэмэгдэл	32,811,937.00	21,266,452.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,720,000.00	10,365,000.00
210104	Урамшуулал	6,560,389.00	10,088,864.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,244,896.00	19,548,459.98
210201	Тэтгэврийн даатгал	13,337,711.08	13,398,619.18
210202	Тэтгэмжийн даатгал	1,474,015.48	1,496,515.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,152,328.79	1,240,886.74
210204	Ажилгүйдлийн даатгал	288,082.69	310,221.70
210205	Эрүүл мэндийн даатгал	2,992,757.96	3,102,216.88
2104	Хангамж, бараа материалын зардал	18,945,220.75	22,596,684.32
210401	Бичиг хэрэг	1,342,800.00	1,020,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,600,206.00	17,103,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,478,034.75	3,609,384.32
210404	Ном, хэвлэл	00.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,524,180.00	768,000.00
2105	Нормативт зардал	616,700.00	215,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	616,700.00	215,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,290,900.00	11,400,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,191,000.00	00.00
210604	Урсгал засвар	8,099,900.00	11,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,644,000.00	6,194,500.00
210702	Дотоод албан томилолт	6,644,000.00	6,194,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,386,821.00	570,276,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,764,221.00	569,560,352.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,600.00	138,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.00	134,468.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	406,000.00	400,000.00

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,392,200.00	35,466,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,999,800.00	7,418,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,392,400.00	28,048,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	176,999,998.25	389,624,691.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,279,300.00	382,263,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,116,700.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	10,205,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,062,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	92,100,000.00	372,057,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,720,698.25	7,361,491.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,720,698.25	7,361,491.71
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>41,914,600.00</u>	<u>59,218,700.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,914,600.00	59,218,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,914,600.00	59,218,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	41,914,600.00	59,218,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,914,600.00	59,218,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-41,914,600.00</u>	<u>-59,218,700.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Лөгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,621,105.00	517,733.50	-51,090,310.94	00.00	84,048,527.56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	134,621,105.00	517,733.50	-51,090,310.94	00.00	84,048,527.56
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,621,105.00	198,417.50	36,467,169.91	0.00	171,286,692.41
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,621,105.00	198,417.50	36,467,169.91	0.00	171,286,692.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	198,417.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	134,621,105.00	198,417.50	36,467,169.91	00.00	171,286,692.41
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-198,417.50	00.00	00.00	-198,417.50
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-35,238,514.62	00.00	-35,238,514.62
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,621,105.00	00.00	1,427,072.79	00.00	136,048,177.79

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	877,015,600.00	869,654,108.29	7,361,491.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	877,015,600.00	869,654,108.29	7,361,491.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	854,752,400.00	847,390,908.29	7,361,491.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,071,600.00	155,070,943.99	656.01
210101	Үндсэн цалин	113,350,800.00	113,350,627.99	172.01
210102	Нэмэгдэл	21,874,800.00	21,266,452.00	608,348.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,365,000.00	10,365,000.00	0.00
210104	Урамшуулал	9,481,000.00	10,088,864.00	-607,864.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,549,500.00	19,548,459.98	1,040.02
210201	Тэтгэврийн даатгал	13,571,100.00	13,398,619.18	172,480.82
210202	Тэтгэмжийн даатгал	1,494,600.00	1,496,515.48	-1,915.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,195,700.00	1,240,886.74	-45,186.74
210204	Ажилгүйдлийн даатгал	298,900.00	310,221.70	-11,321.70
210205	Эрүүл мэндийн даатгал	2,989,200.00	3,102,216.88	-113,016.88
2104	Хангамж, бараа материалын зардал	19,557,800.00	19,557,684.32	115.68
210401	Бичиг хэрэг	1,020,000.00	1,020,000.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	14,064,300.00	14,064,300.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,609,500.00	3,609,384.32	115.68
210404	Ном, хэвлэл	96,000.00	96,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	768,000.00	768,000.00	0.00
2105	Нормативт зардал	215,000.00	215,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	215,000.00	215,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,968,900.00	11,968,900.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	568,900.00	568,900.00	0.00
210604	Урсгал засвар	11,400,000.00	11,400,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	6,194,500.00	6,194,500.00	0.00
210702	Дотоод албан томилолт	6,194,500.00	6,194,500.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	624,886,300.00	617,526,620.00	7,359,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	624,166,700.00	616,810,152.00	7,356,548.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,600.00	138,000.00	600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,000.00	134,468.00	2,532.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	400,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17308800.00	17308800.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,418,000.00	7,418,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,890,800.00	9,890,800.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22263200.00	22263200.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,263,200.00	22,263,200.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,205,400.00	10,205,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,057,800.00	12,057,800.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	877,015,600.00	869,654,108.29	7,361,491.71
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	877,015,600.00	869,654,108.29	7,361,491.71
132001	Орон нутгийн төсвөөс	877,015,600.00	869,654,108.29	7,361,491.71
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10.00	10.00	0.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		392,597,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		392,597,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		32,597,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		3,039,000.00
210402	Тээвэр, шатахуун		3,039,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		11,400,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		11,400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		18158000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		18,158,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		360000000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		360,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		360,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		392597000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		392,597,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		12,597,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		360,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг нутгийн өөрөө удирдах байгууллага юм.

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2022 онд Шинэчлэн батлагдсан Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийг шат шатны хурлын төлөөлөгчдөд сурталчлах, тус хуулийн хэрэгжилтийг хангах, хурлын ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгыг тавьж ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын ажлын албаны дарга нь аймгийн ИТХ-ын даргаар 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулан хэрэгжилтийг 88.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд дотоод хяналтын нэгжгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ИТХ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн боловч Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтуудын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан, Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тайлбар тодруулгыг бүрэн ирүүлээгүй бөгөөд аудитыг гүйцэтгэж байх хугацаанд бэлтгэж ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол, соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ИТХ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,157.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	79.8	-	-79.8
Бараа материал	11,662.5	13,684.4	2,021.9
Үндсэн хөрөнгө	159,544.4	122,444.8	-37,099.6
Нийт хөрөнгө	171,286.7	136,129.1	-35,157.5
Өр төлбөр	-	80.9	80.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	171,286.7	136,048.2	-35,238.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	171,286.7	136,129.1	-35,157.5

Дээрх хүснэгтээс харахад бараа материалын данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд 122,897.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж 1,320.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн, төсвийн хөрөнгөөр 126,239.7 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан зэрэгтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь төсвийн хөрөнгөөр 59,218.7 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэсэн, бусад эх үүсвэрээс 6500.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан бөгөөд 2,501.0 мянган төгрөгийн хөрөнгийг аталж устгасан, 89,988.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилүүлсэн, тайлант онд 55,203.4 мянган төгрөгийн элэгдэл хоргодлын зардал хасагдсан зэрэг нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 623,512.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж төвийн саналаа нэгтгүүлсэн байна.

Төсвийн төслийн санал дээр 19,046.5 мянган төгрөгийн төсвийг нэмж анх 642,558.7 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна. Төсвийг 19,046.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь сургалт семинар, үнэдсэн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны анх батлагдсан төсвийг нийт 234,45.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээг хэрэгжүүлэх 877,015.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 877,015.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулагдаагүй үлдэгдэл 7,361.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 869,654.1 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 7,361.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %
1	Орон нутгийн өрөө удирдах ёсны байгууллага	699,055.6	699,050.6	5.0	100.0
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	177,960.0	170,603.5	7,356.5	95.9
	Дүн	877,015.6	877,015.6	869,654.1	7,361.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цагаатгалын зардлын санхүүжилтэд 360,000.0 мянган төгрөг, Үндсэн хуулийн 30 жилийн ойн арга хэмжээний санхүүжилтэд 20,000.0 мянган төгрөг, Төлөөлөгчдийг чадавхжуулах сургалтын унааны хөлс 1,197.0 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 11,400.0 мянган төгрөг нийт 392,597.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Тээвэр, шатахууны зардалд зардалд 3,039.0 мянган төгрөгийг, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 11,400.0 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 18,158.0 мянган төгрөгийг, цагаатгалын зардалд 360,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Аймгийн ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/37 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 1.5 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 8,518.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,388.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллагын үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн.

Горим сорилыг хэрэгжүүлэх явцад байгууллагын төсвөөс 775.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч зарцуулсан, хууль, журмаар хүлээн зөвшөөрөгдөөгүй зардал гарган Хөвсгөл аймгийн Ардчилсан намд 44,000.0 мянган төгрөг, Монгол ардын намд 36,000.0 мянган төгрөг, бие даан нэр дэвшигч Д.Лхагвасүрэнд 2,000.0 мянган төгрөг нийт 82,000.0 мянган төгрөгийн

дэмжлэгийг тус тус олгосон, төлөөлөгчдийн хуралдааны хоолны зардалд 2,437.0 төгрөгийг зарцуулсан, бүсийн сургалтын арга хэмжээний зардалд 3,182.8 мянган төгрөгийг хоол хүнс, бэлэг дурсгалын зүйл, ус ундааны зардалд зуруулсан зэрэг зөрчил илэрсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардлыг 41 төлөөлөгчийн хувийн дансаар дамжуулан нийт 205,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4. “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.8. “Төлөөлөгчийн зардлыг бэлнээр олгохгүй бөгөөд үнийн нэхэмжлэх болон бусад баримтыг үндэслэн зардлын хязгаарт багтаан холбогдох санхүүжилтийг тухайн байгууллагад шилжүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 351,800.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	351,800.0	2	351,800.0	100
Нийт дүн	2	351,800.0	2	351,800.0	100

Өмнөх оны аудитаар өгсөн 351,800.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн тойрогт ажиллах үйл ажиллагааны зардлыг “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу зарцуулж үр дүнг тооцон ажилласан эсэхэд анхаарал хандуулах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 294,913.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Аудитын явцад 1,518.4 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн тооцооллын 2 алдааг залруулж, 2,437.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг өгч 85,182.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 205,000.0 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх 1 албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Залруулсан алдаа.

Шилжүүлсэн 1,320.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгө данснаас хассан гарзаар бүртгэснийг үнэ төлбөргүй гаргасан зардалд бүртгүүлж засуулсан, Өмчийн өөрчлөлтийн тайлангийн Дахин үнэлгээний нөөцийг 198,417.5 мянган төгрөгөөр буруу илэрхийлснийг тус тус залруулсан

5.1 Төлбөрийн акт

Аудитаар илэрсэн 85,182.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн. Үүнд:

- Байгууллагын төсвөөс 775.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан. энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-гүй байх гэсэн заалттай тус тус нийцээгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй зардал гарган намын суудлын мөнгө гэж Ардчилсан намд 44,000.0 мянган төгрөг, Монгол ардын намд 36,000.0 мянган төгрөг, Д.Лхагвасүрэнд 2,000.0 мянган төгрөг нийт 82,000.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2."өрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 25 дугаар зүйлийн 25.10."Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3."хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-гүй байх, гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Бүсийн сургалтын арга хэмжээний зардалд 3,182.8 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч анхан шатны баримт байхгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3."сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

- Төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардал гэж 205,000.0 мянган төгрөгийг нийт 41 төлөөлөгчийн хувийн дансанд шилжүүлэн олгосон бөгөөд төлөөлөгчдийн хийсэн ажлын баримт материал зарцуулалтын тайлан байхгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.8."Төлөөлөгчийн зардлыг бэлнээр олгохгүй бөгөөд үнийн нэхэмжлэх болон бусад баримтыг үндэслэн зардлын хязгаарт багтаан холбогдох санхүүжилтийг тухайн байгууллагад шилжүүлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж

мэдэгдлийг хангахгүй байна. Имээс зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын төсвөөс төлөөлөгчдийн хуралдааны хоолны зардалд 2,437.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцэхгүй байна..

Өгсөн зөвлөмж: Байгууллагын төсвөөс хоолны зардал гаргахгүй байх.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, дотоод хяналтын нэгжгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын нэгж байгуулан Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж дотоод хяналтын нэгжийг ажиллуулах.

3. Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тодруулга тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн ирүүлээгүй бөгөөд аудитын хугацаанд нөхөж ирүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 "санхүүгийн тайлангийн тодруулга", Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4."хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан", 54.5.5."нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга", Сангийн сайдын 206 оны 388 дугаар тушаалаар баталсан заавар аргачлалтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгуудыг гаргаж санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нягтлан бодох бүртгэлийн алдаа	2	1,518.4			2	1,518.4	2	1,518.4				
Дүн	2	1,518.4			2	1,518.4	2	1,518.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	7	293,394.8	2	85,182.8	1	205,000.0	3	2,437.0
Дүн	7	293,394.8	2	85,182.8	1	205,000.0	3	2,437.0

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО: